ДОРНОД АЙМАГ ДАХЬ УЛСЫН

БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

# 2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Чойбалсан хот

2021 он

АГУУЛГА

НЭГ. БИДНИЙ АМЖИЛТ, ЗОРИЛТ, ҮНЭТ ЗҮЙЛС

ХОЁР. ХҮНИЙ НӨӨЦ

ГУРАВ. ШИНЭЭР САНААЧИЛСАН БҮТЭЭЛЧ АЖИЛ

ДӨРӨВ. ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ТАВ. ХАМТЫН АЖИЛЛАГАА, СУРГАЛТ

ЗУРГАА. ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ

ДОЛОО . БҮРТГЭЛИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТ, ХАРЬЦУУЛАЛТ

- Бичиг хэргийн эргэлт
- Бүртгэл хяналтын чиглэлээр
- Иргэний улсын бүртгэл
- МУЕСонгууль
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл
- Хуулийн этгээдийн улсын бүртгэл
- Архивын чиглэлээр хийсэн ажил

НАЙМ. САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР

ЕС. ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, САНАЛ ХҮСЭЛТ ШИЙДВЭРЛЭЛТ

АРАВ. ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР

АРВАН НЭГ. АЮУЛГҮЙ БАЙДАЛ

АРВАН ХОЁР. БУСАД

АРВАН ГУРАВ. ДҮГНЭЛТ

## НЭГ. БИДНИЙ АМЖИЛТ, ЗОРИЛТ, ҮНЭТ ЗҮЙЛС

Дорнод аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс нь тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, цаг үетэйгээ холбогдуулан зохион байгуулсан шинэлэг, онцлог ажил үйлчилгээ, мөн хамт олны нэгдмэл зохион байгуулалт, ажил үүргээ оновчтой зөв зохион байгуулсны үр дүнд системийнхээ хэмжээнд дараах амжилтуудыг он дараалан үзүүлсэн.

- 2016 онд “ДӨТГӨӨР БАЙР”
- 2017 онд “ДЭД БАЙР”
- 2019 онд “ТЭРГҮҮН БАЙР”
- 2020 онд “ТАВ ДУГААР БАЙР”



### ЗОРИЛТ, ҮНЭТ ЗҮЙЛС

Бид 2021 оныг Нэгжийн үндсэн чиг үүрэг болох бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах, цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан “БҮРТГЭЛИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ- БҮХ НИЙТИЙН ХЭРЭГЛЭЭ" зорилтот жил болгон зарлаж, 16 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллалаа. Төрийн цахим үйлчилгээг иргэд олон нийтэд сурталчлан ажилласнаар төрийн үйлчилгээг цаг хугацаа орон зайнаас үл хамаарч авахаас гадна болзошгүй эрсдлээс өөрийгөө болон гэр бүлээ хамгаалах эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлэх юм.

***БИД:***

***ЭВИЙГ ЭРХЭМЛЭГЧ, ИРГЭНДЭЭ ОЙР***

***ЧАНАР, ИЛ ТОД ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДЛЫГ ЭРХЭМЛЭГЧ***

***МАНЛАЙЛАГЧ ХАМТ ОЛОН.***

## ХОЁР. ХҮНИЙ НӨӨЦ

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2018 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн Б/89 тушаалаар хэлтсийн бүтэц, орон тоо батлагдаж төрийн захиргааны албан хаагч -25, төрийн үйлчилгээний ажилтан- 4, гэрээт- 2 нийт 31 албан хаагчтайгаар аймгийн 82 мянга гаруй иргэнд төрийн бүртгэлийн үйлчилгээг хүргэн ажиллаж байна. Үүнээс 6 эрэгтэй, 25 эмэгтэй.




Албан хаагчдыг нас, хүйсээр ангилвал:






Боловсролын түвшингээр нь ангилвал:




Мөн Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангахаар Сити Их сургуулийн эрхзүйн бакалаврын эчнээ ангид 5 албан хаагч, магистрийн ангид 4 албан хаагч, Глобал Удирдагч Их сургуульд эрхзүйн бакалаврын эчнээ ангид 5 албан хаагч, магистрийн ангид 4 албан хаагч нийт 14 албан хаагч суралцаж байна.

Мэргэжлээр ангилвал:




Бүртгэлийн байгууллагад ажилласан жилээр нь ангилвал:




**2021** онд шинээр **4** албан хаагч ажилд орсон. Үүнээс:

**4**
**Дээд боловсролтой**

**4** 

Шинээр ажилд орсон ажилтны 5 жилийн судалгаа




Чөлөөлөгдсөн ажилтны сүүлийн 5 жилийн судалгаа




**Тэтгэвэрт 2 албан хаагч, өөрийн хүсэлтээр 2 албан хаагч шилжиж, 10 албан хаагч ажлаас чөлөөлөгдсөн байна.**

*Төрийн албан хаагчийн дэлгэрэнгүй, Төрийн албанд ажилласан жилийн, зэрэг дэвийн, нас, хүйс, боловсрол, мэргэжил гэх мэт суурь 14 судалгааг шинэчлэн гаргасан.*

*Төрийн захиргааны 3, гэрээт албан хаагчийн 1 сул орон тооны мэдээллийг байгууллагын www.ubh.dd.gov.mn цахим хаягт байршуулж мэдээлж ажиллав.*

| ***Д/д*** | ***Тушаал, шийдвэр*** | ***Төрөл*** | ***Албан хаагчдын тоо*** |
|---|---|---|---|
| *1.* | *Хэлтсийн даргын 2021 оны А/13* | *Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэн урамшуулал олгосон* | *27* |
| *2.* | *УБЕГ-ын даргын 2020 оны Б/156* | *Зэрэг дэвийн нэмэгдэл* | *21* |
| *3.* | *УБЕГ-ын даргын 2020 оны Б/26, Хэлтсийн даргын 2021 оны А/01* | *Албан тушаалын цалингийн шатлал ахиулах* | *14* |
| *4.* | *Хэлтсийн даргын 2021 оны А/01, А/03* | *Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл* | *3* |




Монгол улсад бүртгэлийн байгууллага үүсч хөгжсөний 81 жилийн ойн баярын хүрээнд Засгийн газрын шагналаар 1 албан хаагч, ХЗДХЯамны шагналд 3 албан хаагч, УБЕГ-ын шагналд 3 албан хаагчийг, Аймаг орон нутгийн шагналд 4 албан хаагчийг тус тус шагнуулахаар тодорхойлсон бөгөөд аймгийн шагналууд батлагдав.

“Бүртгэлийн ажилтны үйлчилгээний стандарт”-ын дагуу албан хаагчдын хувцаслалт, ажлын үнэмлэх, энгэрийн тэмдгийг шинэчлэн, стандартыг хэрэгжүүлж ажиллалаа.

Албан хаагчдын нийгмийн баталгааг хангахаар Зүүн бүсийн оношилгоо, эмчилгээний төвтэй хамтран ажиллах хүрээнд хэлтсийн 652 тоот албан бичгээр 31 албан хаагчийн урьдчилан сэргийлэх багцын үзлэгт хамруулсан.

## ГУРАВ. ШИНЭЭР САНААЧИЛСАН БҮТЭЭЛЧ АЖИЛ:

Бүртгэлийн байгууллагын түүхийн хуудаснаа өөрийн мэдлэг чадвар, оюун ухаанаа дайчлан ажиллаж, үнэтэй хувь нэмэр оруулсан үе үеийн ажилтан албан хаагчид болон ирээдүй хойч үеийнхэндээ зориулж Дорнод аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн “ҮҮСЭЛ ХӨГЖЛИЙН МОД” бүтээлээ. Уг үүсэл хөгжлийн модонд 2009 оноос одоог хүртэл ажилласан болон ажиллаж буй үе үеийн хэлстийн удирдлага, нэгжийн дарга, албан хаагчдыг он цагийн дараалаар байршуулав.



Бүртгэлийн байгууллагын он цагийн хэлхээс, онцлогийг илтгэсэн иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хэрэглэгдэхүүн болох тухайн он жилүүдийн гэрчилгээ, холбогдох бичиг баримт, тоног төхөөрөмжөөр “ТҮҮХЭН БУЛАН” байгуулав.








Улсын бүртгэлийн үйлчилгээний шат дамжлагыг бууруулах, түргэн шуурхай, хүртээмжтэй болгох чиглэлээр үйлчилгээний төлбөр, хураамжийг боловсронгуй болгох, иргэдэд түргэн шуурхай үйлчлэх зорилгоор ГЭРЭГЭ КИОСК байршуулсан бөгөөд тайлант хугацаанд 1641 иргэнд үйлчилж ажилласан.




Нярай хүүхэдтэй эцэг, эхчүүдийн ая тухтай үйлчилгээ авах, хүүхдийн аюулгүй байдлыг хангах үүднээс өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан хүүхдийн булан болон хүүхэд хуурайлах ор байрлуулж тохижуулав.





Дорнод аймгийн 13 сумын архивт хадгалагдаж буй Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн сангийн 1951-1988 оны





бүртгэлийн дэвтрийг 100 хувь, хэлтсийн иргэний улсын бүртгэлийн архивт хадгалагдаж буй бүртгэлийн дэвтрийг 50% хувийн гүйцэтгэлтэйгээр скайнардаж "АРХИВЫН ЦАХИМ САН"-г санаачлан үүсгэсэн.

Хүний нөөцийн ажлын хэсгээс санаачлан шинээр томилогдсон албан хаагчдадаа зориулан "Бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандарт" болон хууль, журмын эмхэтгэл номнууд, 2 ээлжийн дүрэмт хувцас, бичиг хэргийн хэрэгслийг бэлтгэн УГТАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ зохион байгуулав.

## ДӨРӨВ. ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Азийн хөгжлийн банкнаас "Нийгмийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зорилгоор бүртгэлийн системийг боловсронгуй болгох" төсөл УБЕГазартай хамтран 2018 оноос сум, хороодыг Улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээнд холбох ажлыг шат дараатай хийж хэрэгжүүлж ирсэн. Дээрх ажлын хүрээнд тус аймгийн Иргэний улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээнд холбогдоогүй ХАЛХГОЛ, ЧУЛУУНХОРООТ, ДАШБАЛБАР сумдыг сүлжээнд холбосноор Дорнод аймгийн 14 сум Иргэний улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээнд бүрэн холбогдлоо.




Улсын бүртгэлийн ерөнхий газар БНСУ-ын Солонгосын олон улсын хамтын ажиллагааны байгууллага буюу КОЙКА-гийн буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй "Улсын бүртгэлийн системийн үйл ажиллагааг дэмжих төсөл"-ийн хүрээнд техник, тоног төхөөрөмж болох компьютер, олон үйлдэлт принтер, хурууны хээ уншигч, зургийн аппаратыг хүлээн авч компьютерт Civilregoffline програмын баазыг хуулан, шаардлагатай бүх програмыг таниулан суулгаж, сериал дугаараар нь бүртгэж, лацдан 14 сумын улсын бүртгэгч нарт хүлээлгэн өгч ажилласан.





Зорилтот жилийн хүрээнд бүртгэлийн цахим үйлчилгээг иргэдэд таниулан сурталчлах ЦАХИМ_БУЛАН ажиллуулж хэвшээд байна. Энэхүү буланг ажиллуулснаар иргэн, аж ахуйн нэгж нь улсын бүртгэлийн үйлчилгээний талаарх лавлагаа, мэдээллийг шууд хэвлэн авахаас гадна иргэний цахим үнэмлэх, үндэсний энгийн гадаад паспорт онлайнаар захиалж байна.





Тус хэлтэс нь иргэдийн цахим хэрэглээг нэмэгдүүлэхээр ”ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭГ ХЭРЭГЛЭЭ БОЛГОЦГООЁ” уриалга бүхий сарын аянг зарлаж, хэрэгжилтийг дүгнэн



ажиллалаа.

Аяны хүрээнд Зүүн бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газар болон Халхгол суман дахь гал унтраах 62-р анги, Баян-Уул суман дахь 53-р ангийн нийт 173 албан хаагчдад , Хэрлэн номин бизнес төв, Тана, Шүр, Сувд захын түрээслэгчдэд, Дорнод аймгийн Авто тээврийн төвийн албан хаагчдад тус тус Гэрэгэ киоск, Emongolia үйлчилгээний талаарх зөвлөгөө мэдээллийг хүргэж нийт 720 гаруй иргэнд ЯВУУЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ үзүүлж, гарын авлагаар хангаж ажилласан байна.







“Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 01 дүгээр албан даалгавар, 2018 оны Засгийн газрын 32 дугаар “Хариуцлагын жил болгон зарлах тухай” тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд “ХАРИУЦЛАГАТАЙ ТӨРИЙН АЛБАН ХААГЧ” аяныг зохион байгуулан ажиллаж байна.

Төрийн албан хаагчдын манлайлал, үйлчилгээний стандарт, ёс зүй, харилцаа хандлага, хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт цахим сургалтыг зохион байгуулж, 26 алба албан хаагчийг хамрууллаа.






Хүний амьдралын аз жаргал, баяр баясгалантай мөчүүдийн нэг бол гэрлэх ёслол, гэрлэлтийн баталгаа юм. Ирээдүйн амьдралаа холбож, гэрлэлтээ бүртгүүлж буй бүх хосуудад "ГЭРЛЭХ ЁСЛОЛ"-ын булан нээлттэй бөгөөд хосуудын зөвшөөрлийн дагуу зургийг нь авч, сар бүр видео бичлэг болгон пэйж хуудсандаа байршуулж байна.





## ТАВ. ХАМТЫН АЖИЛЛАГАА, СУРГАЛТ

2021 онд хийж хэрэгжүүлэх ажил, үүрэгтэй холбоотойгоор Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргатай 41 арга хэмжээ бүхий гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулан, биелэлтийг ханган ажиллаж байна.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төлөвлөгөөг хянасан: Төсвийн Ерөнхийлөн захирагч
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА........................................../Д.ДЭЛГЭРСАЙХАН/
(албан тушаал) (гарын үсэг)
Тэмдэг 2021/03/03
(огноо)

Төлөвлөгөө баталсан: Төсвийн Шууд захирагч
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА........................................../Д.ОЮУНБАЯР/
(албан тушаал) (гарын үсэг)
Тэмдэг
(огноо)

2021 онд хийж хэрэгжүүлэх ажил, үүрэгтэй холбоотойгоор аймгийн Засаг даргатай 44 арга хэмжээ бүхий гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулан, биелэлтийг ханган ажиллаж байна.





Тус хэлтэс нь Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын 1 дүгээр давхарыг түрээслэн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тус байгууллагын удирдлагуудад хүсэлт тавьсны дагуу үүдний хэсэгт 12.0 сая төгрөгний өртөг бүхий УРСГАЛ ЗАСВАР хийж, хэлтсийн албан хаагчдын ажиллах нөхцөл, иргэдийн ая тухтай үйлчлүүлэх боломжийг бүрдүүллээ.







Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуультай холбогдуулан аймгийн Тагнуулын зүүн бүс дахь газрын даргатай хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулан баталж, биелэлтийг хангаж ажиллав. Мөн аймгийн Засаг даргын Тамгын газар, Хууль, эрх зүйн хэлтэс, Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Гадаадын иргэн, харьяатын газрын зүүн дэх газар, Газрын харилцаа, хот байгуулалтын газар, Орон нутгийн өмчийн газар, аймгийн Татварын хэлтэс, Статистикийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Хүүхэд гэр, бүл хөгжлийн газар зэрэг байгууллагуудтай өдөр тутмын үйл ажиллагаагаар хамтран ажиллаж байна.





Аймгийн Тагнуулын зүүн бүс дахь газрын төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилт, хадгалалт хамгаалалтын байдалд хийсэн төлөвлөгөөт бус шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгахаар дараахи арга хэмжээг авч ажиллалаа. Үүнд:

- Хэлтсийн төрийн болон албаны нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг шинээр гарган батлав.
- Нууц хамгаалах ажилтанд шаардлагатай суурин компьютерыг байршуулав.
- Нууц хамгаалах ажилтны өрөөг холбогдох хуульд заасны дагуу тохижуулахаар шаардлагатай төсвийг гарган Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлээд байна

Тус хэлтэс нь аймгийн Онцгой комиссын 2021 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 23 тоот тогтоолоор "Буяны ажлыг хянах, зөвлөн туслах комисс", аймгийн Онцгой комиссын 2021 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн шуурхай штабын 59 дүгээр хуралдааны шийдвэрээр "Улаанбаатар хотоос зорчих иргэдийн хөдөлгөөнийг зохицуулах ажлын хэсэг"-ийн бүрэлдэхүүнд тус тус орж ажилласан.

Буяны ажлыг хянах, зөвлөн туслах комисст тус хэлтэс нь нас барсан иргэний мэдээллийг гарган өгөх, нас барсны бүртгэл хийлгэх гэж ирсэн иргэнд эрүүл мэндийн байгууллагаас гаргасан санамж, зөвлөмж, буяны ажилд оролцох иргэдийн бүртгэлийг хөтлөх маягт, "Буяны үйл ажиллагаа зохицуулах түр журам"-ыг танилцуулж, хэвлэн өгөх, нас барсан иргэний мэдээллийг сумын Онцгой комисст мэдээлэх, нас барсан иргэний төрөл садан мөн эсэхийг тодруулах зэрэг ажлыг хариуцан, нас барсан иргэний мэдээллийг хүргүүлж ажилласан.

Улаанбаатар хотоос зорчих иргэдийн хөдөлгөөнийг зохицуулах ажлын хэсэгт тус хэлтэс нь аймгийн Онцгой комисст Дорнод аймагт нэвтрэн орох зөвшөөрөл хүссэн иргэдийн байнга оршин суугаа хаягийн мэдээллийг тулган, нягтлан шалгах ажлыг хариуцан ажиллаж байна. Тайлант хугацаанд 1586 иргэний мэдээллийг нягтлан шалгасан.

Аймгийн Онцгой комиссын шуурхай штабт ирсэн дуудлага болон цахим шууданг хүлээн авч, хариу мэдэгдэх ажилд 2 албан хаагч 4 удаа ажилласан.

- Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж буй "ЗӨВ ЗӨВД ШУДАРГА ЗӨВ" аяны хүрээнд хууль сурталчлах нэгдсэн арга хэмжээнд оролцож, оролцогч байгууллагын албан хаагчдад болон иргэдэд Emongolia, Гэрэгэ киоск машины талаар мэдээлэл, сурталчилгаа хийж ажиллалаа. Иргэд дээрх 2 үйлчилгээг ашигласнаар авлига, ашиг сонирхол, хүнд суртлаас ангид байж, цаг хугацаа, төлбөр мөнгөө хэмнэх боломжтойг сурталчлан ажилласан.








- Аймгийн Засаг даргын Тамгын газар, Гэр бүл, Хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран залуу үеийнхэнд эх оронч сэтгэлгээг төлөвшүүлэн, төр улсаа эрхэмлэн дээдлэх, эх орон ард түмнийхээ өмнө хүлээх хариуцлагаа ухамсарлан чин шударгаар амьдрах, түүх соёлоороо бахархах үзлийг төлөвшүүлэх зорилгоор “ИРГЭНИЙ АНДГАЙ ӨРГӨХ ЁСЛОЛ”-ыг зохион байгууллаа.




Аймгийн Засаг дарга М.Бадамсүрэнтэй агентлаг хэлтсийн удирдлагууд Хэрлэн сумын 11 багийн иргэдтэй уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, иргэдийн санал хүсэлтийг сонслоо.






Аймгийн Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албаны ерөнхий шалгалт”-д орох иргэдийн бүртгэлийг биеийн давхцахгүй өгөгдөл /гар, хурууны хээ/-өөр таньж оруулахад 2 удаа хамтран ажилласан.

Улсын хэмжээнд 5 жил тутам зохион байгуулагддаг ААНБ-ын тооллого энэ онд явагдаж дууслаа. Дорнод аймгийн тооллогын коммист Хэлтсийн дарга, Хэрлэн сумын тооллогын коммист Хуулийн этгээдийн улсын бүртгэгч нар тус тус томилогдон тооллогын үйл ажиллагаанд дэмжлэг туслалцаа үзүүлэн хяналт тавьж ажилласан. Тооллогоор сум бүрт төрийн сангийн мэргэжилтэнүүд аймгийн төвт 11 тоологч нарт томилогдон ажиллаж ААНТ-ын 4 төрлийн маягтын дагуу 2778 ААНБ-ыг 100% тоолон баталгаажуулан гэрчилгээ олгосон байна.




Төрийн албан хаагчийн мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилтын хүрээнд “СИТИ ИХ СУРГУУЛЬ” болон “ГЛОБАЛ УДИРДАГЧ ИХ СУРГУУЛЬ”-тай хамтран ажиллах гэрээ байгуулан Эрх зүйч мэргэжлээр бакалавр 8, эрх зүйн магистрт 6 албан хаагчийн төлбөрийг 20-30%-ийн хөнгөлөлттэй нөхцлөөр суралцуулж байна.

Жендерийн үндэсний хорооноос “Монгол цэргийн өдөр”-ийг тохиолдуулан “Би



жендерийн хэвшмэл байдлын эсрэг байна” уриатай “БИ... БАЙНА” аянд тус хэлтсийн 29 албан хаагч 100 хувь нэгдэж фэйсбүүк хуудасны профайлны зургаа сольлоо.

Дорнод аймгийн залуучуудын хөгжлийн шийдэл ТББаас зохион байгуулсан “НЭГ ӨДРИЙН ЦАЛИН, НЭГ ХҮНИЙ АМЬ” хандивын аянд хамт олноороо нэгдэж, нэг өдрийн цалингаараа хувь нэмэр оруулав.




Ковид-19 цар тахал, хүчирхийллээс хамгаалах, осол гэмтэлт өртхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хүүхдээ “АНХААРЧ ХАМГААЛЬЯ” 100 хоногийн аянд байгууллагын эцэг эхийн зөвлөл нэгдэж Дорнод аймгийн “Гэр бүл хүүхэд, залуучуудын хөгжлийн газар”-тай хамтран ажилласан.






СУРГАЛТ

- Хэлтсийн хэмжээнд 22 нэр төрлийн сургалт зохион байгуулахаар төлөвлөгөөнд тусгаснаас жилийн эцсийн байдлаар нийт 36 сургалт /бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой 12 сургалт, албан хаагчдийн хандлага, хариуцлага болон бусад чиглэлээр 7, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтарсан 13, сонгуулийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх чиглэлээр 4 / зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 234 албан хаагч хамрагдахаас 234 албан хаагч хамрагдаж ирц 100 хувь, төрийн байгууллагын 337 албан хаагч хамрагдсан байна.

- Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан 18 удаагийн онлайн сургалтанд /бүртгэлийн чиглэлээр-8, хяналт, шалгалтын чиглэлээр-1, сонгууль- 1, бусад - 8, давхардсан тоогоор нийт 62 албан хаагчид бүрэн хамрагдаж, мэдлэг, ур чадвараа дээшлүүлсэн.

Өөрсдийн нөөц бололцоондоо тулгуурлан 2021 оны сургалтын төлөвлөгөөний дагуу дараах сургалтуудыг зохион байгуулав. Үүнд:

- ❖ Сумдын улсын бүртгэгч нарт иргэний улсын бүртгэлийн талаар анхаарах асуудал болон шилжилт хөдөлгөөн, хяналт шалгалтаар гарсан зөрчлийг арилгах талаар онлайн сургалтыг 3 удаа хийв.
- ❖ УБЕГ-аас 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдөр Ерөнийлөгчийн сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулсан цахим сургалтад хэлтсийн дарга, иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын ахлах бүртгэгч, сургалтын ажлын хэсгийн ахлагч нар хамрагдаж, аймгийн итгэмжлэгдсэн ажилтнуудад зохион байгуулах цахим сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг батлуулан ажиллалаа.





БАТЛАВ
ХЭЛТСИЙН ДАРГА Д.ОЮУНБАЯР
2020.05.15

УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ИТГЭМЖЛЭГДСЭН АЖИЛТАНД ЗОРИУЛСАН ЦАХИМ БОЛОН ТАНХИМ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

НЭГ.СУРГАЛТЫН ЗОРИЛГО

1.1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, түүнтэй холбоотой хууль тогтоомжийг нэг мөр ойлгон хэрэгжүүлэх, санал авах өдөр сонгогчийн бүртгэлийг нэгтгэн шалгахтай холбоотой анхаарах асуудлуудын талаар улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтанд сургалт зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангахад оршино.

ХОЁР.ХАМРАХ ХҮРЭЭ, ХУГАЦАА

2.1.Цахим сургалт 2020 оны 05 дугаар сарын 19-ний өдөр сумдын улсын бүртгэгч нарын албан өрөөнд.
2.2.Танхимын сургалт 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдөр аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд болно.

ГУРАВ.СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

3.1. Онлайн сургалт /2020.05.19/

| № | Агуулга | Хугацаа | Албан тушаалтны нар |
|---|---|---|---|
| 1 | Онлайн холболт Бүртгэл | 14.45-15.00 | Сургалтын ажлын хэсэг Мэдээлэл технологийн ажилтан А.Гэрэлцогт |
| 2 | Нээлт | 15.00-15.10 | Хэлтсийн дарга Д.Оюунбаяр |
| 3 | Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль | 15.10-15.30 | Хэлтсийн дарга Д.Оюунбаяр |
| 4 | Иргэний улсын бүртгэл ба сонгогчийн бүртгэл | 15.30-15.45 | Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч А.Наранчимэг |
| 5 | Төрийн нууцын хадгалалт, хамгаалалт, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах талаар | 15.45-16.00 | Тагнуулын байгууллагын ажилтан |
| 6 | Сонгогчийн нэрийн жагсаалт үйлдэх, сонгогч шилжих журам | 16.00-16.20 | Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч А.Наранчимэг |
| 7 | Итгэмжлэгдсэн ажилтантай гэрээ байгуулах, нууцын баталгааны талаар анхаарах асуудал | 16.20-16.45 | Хэлтсийн дарга Д.Оюунбаяр |

“Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль”, “Итгэмжлэгдсэн ажилтантай гэрээ байгуулах, нууцын баталгааны талаар анхаарах асуудал” сэдвээр хэлтсийн дарга Д.Оюунбаяр, “Иргэний улсын бүртгэл ба сонгогчийн бүртгэл”, “Сонгогчийн нэрийн жагсаалт үйлдэх, сонгогч шилжих журам” сэдвээр иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч А.Наранчимэг, “Төрийн нууцын хадгалалт, хамгаалалт, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах талаар” сэдвээр Дорнод аймаг дахь Тагнуулын газрын хурандаа Б.Чинбат, “Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтны ёс зүй, гэрээгээр хүлээх үүрэг, хариуцлага” сэдвээр сургалтын ажлын хэсгийн ахлагч улсын бүртгэгч Д.Ууганчимэг нар сургалт хийв.






Сургалтыг 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 14:00 цагаас цахимаар 1 удаа зохион байгуулж үндсэн 72, нөөц 19 итгэмжлэгдсэн ажилтнуудыг 100 хувийн ирцтэйгээр хамруулан итгэмжлэгдсэн ажилтнуудтай гэрээ байгуулж, нууцын баталгааг баталгаажуулан авав.





Монгол улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулиар ажиллах Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтны сургалт 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулагдаж, 72 хэсгийн 72 итгэмжлэгдсэн ажилтан 100 хувийн ирцтэйгэр хамрагдлаа. Сургалтын явцад Эрүүл мэндийн газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийн дагуу халдвар хамгаалын дэглэм баримталж, завсарлагаанаар танхимд агааржуулалт, ариутгалыг хийж ажиллав.

Сургалт 09:00 цагт эхлэв. Сургалтыг Дорнод аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Д.Оюунбаяр нээж, УБЕГ-ын сургалтын багийн гишүүдийг танилцуулж, итгэмжлэгдсэн ажилтны ирцийг мэдээлж, сургалтын анги танхимыг ариутган бэлтгэсэн болон Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажилласан талаар илтгэв.






Удирдамжийн дагуу итгэмжлэгдсэн ажилтны тоног төхөөрөмжийн лац тэмдгийг хүлээлцэх протокол үйлдэн нээж, сургалтын горимд дадлага ажлыг эхлүүлэн сонгуулийн өдөр ирц бүртгэлийн программыг асаах, сонгогчийн ирц бүртгэлийг нээж ажиллуулах, сонгогчийн хувийн мэдээллийг нягтлан шалгах, ирцийн мэдээ хэвлэх, бүртгэлийн хуудас хэвлэх, сонгогчдын нэрийн жагсаалтад тусгах лавлагааг ирц бүртгэлийн программд оруулах дадлага ажлыг хийж гүйцэтгэсэн. Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль болон Сонгогчийн нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, давхардлыг шалгах сонгогч шилжих журмын дагуу нийт 707 лавлагаа хэвлэснээс сонгуулийн нэрийн жагсаалтад сонгогч шилжин ирсэн 344, шилжин явсан 344, түр хасав тэмдэглэгээг

сэргээсэн 1, иргэний бүртгэлтэй холбоотой өөрчлөлт 1, нас барсан 17 лавлагааг тусгаж өөрчлөлтийн тайланг хэсэг тус бүрээр нягтлан шалгаж оруулав.

Сонгогчдын нэрийн жагсаалтыг 3 хувь, сонгогчдын нэрийн жагсаалтын өөрчлөлтийн тайланг хэсэг тус бүрт 2 хувь хэвлэн итгэмжлэгдсэн ажилтнаар хуудас нэг бүрийг хянуулан гарын үсэг зуруулан битүүмжилж, программыг акт үйлдэн түгжиж хэсгийн хороодод хүлээлгэн өгөв.





УБЕГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу “УЛСЫН БҮРТГЭГЧ НАРЫН НЭГДСЭН СУРГАЛТ”-ыг 2021 оны 08 дугаар сарын 29-ний өдөр амжилттай зохион байгуулсан.




## ЗУРГАА. ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ

Улсын бүртгэлийн ерөнхий газар болон хэлтсээс зохион байгуулсан үйл ажиллагаа, мэдээ мэдээллийг цаг тухай бүрт нь www.dornod.burtgel.gov.mn, www.facebook.com/Ubh.dornod цахим хуудаснаа нийтлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд цаг үе, үйл явдалтай холбоотойгоор 142, иргэдийн эрх зүйн боловсролыг сайжруулах чиглэлээр цахим хуудсаар хууль сурталчлах 184 баннер, зурагт мэдээлэл байршуулж, цахим хуудасны сэтгэгдэл, захиагаар хандсан 194 иргэнд зохих мэдээлэл, зөвлөгөөг хүргэж ажилласан. www.facebook.com/Ubh.dornod фэйсбүүк хуудас нь 6250 дэмжигчидтэй байна.

Мэдээллийн ил тод байдлыг хангах үүднээс УБЕГ-ын www.burtgel.gov.mn, аймгийн Засаг даргын Тамгын газрын www.dornod.gov.mn хуудсанд тавигдсан мэдээ мэдээллийг байгууллагын цахим хуудсанд хуваалцаж, иргэдийг мэдээ мэдээллээр хангав.




Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор үйлчилгээний танхимд улсын бүртгэгч нарын ажил үүргийн хуваарь, мэдүүлэг хүлээн авах цонхонд үйлчилгээний дансны дугаар шинэчлэн байршуулав.






Иргэд, хуулийн этгээдэд улсын бүртгэлийн үйл ажиллагаа сурталчлах, хуулийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Emongolia үйлчилгээгээр гадаад паспорт, иргэний цахим үнэмлэх хэрхэн захиалах, "Иргэдийн шилжилт хөдөлгөөний бүртгэл зогсоох тухай", сэдвээр орон нутгийн Мижи телевиз болон дагагч ихтэй пэйж хуудаснуудад мэдээлэл тус тус хийсэн.

Байгууллагын пэйж хуудасны хандалтын тоог нэмэгдүүлэх, эерэг уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор өглөө бүр Дорнын зурхай бүхий мэндчилгээг тогтмол байршуулж






хэвшсэн.

Аж ахуй нэгж байгууллагын удирдлагуудыг зөвлөгөө, мэдээ, мэдээллээр хангах өгөх зорилгоор “ДОРНОД АЙМГИЙН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА” цахим хуудас нээн ажиллуулав. Өнөөдрийн байдлаар 215 аж ахуйн нэгж дагагч дэмжигчтэй байна.





Улсын бүртгэлийн хэлтсээр үйлчлүүлж буй иргэн бүрийн санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэж, үйлчилгээний соёл, сэтгэл ханамжийн баталгааг өндөржүүлж, харилцааны болон үйлчилгээний зөрчилгүй хамт олон болох зорилгоор **“УГТАХ, ЛАВЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ”**-г ажиллуулж хэвшсэн бөгөөд тайлант хугацаанд 1304 иргэнд зөвлөгөө, мэдээлэл хүргэн ажиллав.

Улсын бүртгэлийн багц хуулийн үзэл санааг хэрэгжүүлж, бүртгэлийн үйлчилгээг







иргэдэд чирэгдэлгүй, хүртээмжтэй хүргэхээс гадна иргэдийн талархалыг хүлээсэн **“ИРГЭН ТАНЫ ГЭРТ, ГАРТ ҮЙЛЧИЛГЭЭ”**-г үргэлжлүүлэн ажиллуулж байна. Энэхүү үйлчилгээгээр өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гадаад паспорт, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, цахим иргэний үнэмлэх, лавлагаа зэргийг гэрт нь хүргэн өгдөг бөгөөд тайлант хугацаанд 59 иргэнд үйлчилгээ үзүүлсэн.



БАТЛАВ:
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Д.ОЮУНБАЯР

"ИРГЭН ТАНЫ ГЭРТ, ГАРТ"
ИРГЭДЭД ЧИГЛЭСЭН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
УДИРДАМЖ

2019.03.06 Дорнод аймаг

ЗОРИЛГО: Улсын бүртгэлийн багц хуулийн үзэл санааг хэрэгжүүлж, бүртгэлийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй, хүртээмжтэй хүргэхэд оршино.

ХАМРАХ ХҮРЭЭ: Уг үйлчилгээнд бүртгэлийн байгууллагад өөрийн биеэр мэдүүлэг гаргах боломжгүй өндөр настай, хөгжлийн бэрхшээлтэй буюу бусдын асран хамгаалалтанд байдаг, эсвэл бусдыг асардаг иргэд хамрагдана.

ҮЙЛ АЖИЛЛАГАА:

1. Уг үйлчилгээнд хамрагдах талаар иргэд тусхалтсийн нээлттэй утас 98-970-970, www.ubh.dd.gov.mn, www.facebook.com/ubh.dornod цахим хуудсаар болон ажлын байранд ирж албан ёсоор мэдэгдэх;
2. Албан хаагч хавсралтанд тусгагдсан мэдээлэл хүлээн авах хуудасны дагуу иргэдээс дээрх мэдээллийг хүлээн авах бөгөөд хүндэтгэх үзэх шалтгааныг нягталж, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасагт мэдээллийг тухай бүр нэгтгэх.
3. Дараах үйлчилгээг иргэдийн гэрээр үзүүлнэ. Үүнд:
   - ✓ Эд хөрөнгө өмчлөх эрх баталгаажуулах, өмчлөх эрх шилжүүлэх бүртгэл, лавлагааны материал хүлээн авах, хэвлэгдсэн гэрчилгээ, лавлагаа хүлээлгэн өгөх.
   - ✓ Үндэсний энгийн гадаад паспорт, иргэний үнэмлэхний захиалга хүлээн авах, хүлээлгэн өгөх,
   - ✓ Хуулийн этгээдийн лавлагааны материал хүлээн авах, хүлээлгэн өгөх.
2. Гэрээр үйлчилгээ авах иргэдээс авсан мэдээллийн дагуу долоо хоног бүрийн Баасан гаригт иргэдэд гэрээр нь хүрч үйлчлэх, ажлын явцыг долоо хоног бүрээр нэгтгэж, үр тооцож ажиллах.

ХУГАЦАА: 2019.03.11-ний өдрөөс тогтмол

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН: ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН
УЛСЫН БҮРТГЭГЧ П.ШИЖИРБААТАР



“ОНЛАЙН ЛАВЛАГААНЫ СИСТЕМ”-ийг тус хэлтэс нь 2017 онд нэвтрүүлсэн бөгөөд 2021 онд дахин шинэчлэн сайжруулсан. Интернет орчинг идэвхитэй ашигладаг үйлчлүүлэгч иргэд байгууллагын www.ubh.dd.gov.mn цахим сайтын “**ОНЛАЙН ЛАВЛАГААНЫ СИСТЕМ**”-ээр гадаад паспорт, цахим иргэний үнэмлэх, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ зэргийг хэвлэгдсэн эсэхийг регистрийн дугаараараа шалгах боломж бүрдсэн бөгөөд тайлант хугацаанд 947 иргэний мэдээллийг тус системд шивж оруулав.





❖ Улсын бүртгэлийн үйлчилгээг Burtgel.mn болон E-Mongolia-с цахимаар авах боломжтойг иргэдэд сурталчлан ажиллаж, тайлант хугацаанд 35 иргэнд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, гадаад паспорт, иргэний цахим үйлчилгээ үзүүлсэн байна







Байгууллагын “**НЭЭЛТТЭЙ УТАС 98-970-970”** дугаараас иргэд бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой бүхий л төрлийн мэдээллийг авах боломж бөгөөд тайлант хугацаанд 697 иргэнд үйлчлүүлсэн.






Үйлчилгээний хөлс болон төлбөр, хураамж авах хэлбэрийг боловсронгуй болгох, иргэдэд түргэн шуурхай үйлчлэх зорилгоор Төрийн банк, Голомт банктай хамтран “**ПОС ТЕРМИНАЛ”** машин ажиллуулж байгаа бөгөөд тайлант хугацаанд 702 иргэнд үйлчилсэн.




Цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэдээс тогтмол санал, хүсэлтийг хүлээн авч, тухай бүр зөвлөгөө өгч ажиллаж байна.







- Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээний гарын авлагыг шинэчлэн гаргаж байгууллагын www.dornod.burtgel.gov.mn цахим сайт болон Дорнод аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс фэйсбүүк хуудсаар дамжуулан тогтмол сурталчилан ажиллаж байна.







Байгууллагын ил тод нээлттэй байдлыг ханган ажиллах үүднээс байгууллагын ухаалаг самбарт мэдээллийг тогтмол болон байнга шинэчлэн байршуулан ажиллаж байна.















## ДОЛОО . БҮРТГЭЛИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТ, ХАРЬЦУУЛАЛТ

## БИЧИГ ХЭРГИЙН ЭРГЭЛТ




## БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

### БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОО /2016-2021 он/

| Он | Иргэний улсын бүртгэл | Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл | Хуулийн этгээдийн улсын бүртгэл | Архив | Нийт |
|---|---|---|---|---|---|
| 2016 он | 4629 | 1281 | 220 | 225 | 6355 |
| 2017 он | 7000 | 615 | 147 | 384 | 8146 |
| 2018 он | 5060 | 1200 | 350 | 180 | 6790 |
| 2019 он | 3105 | 550 | 180 | 165 | 4000 |
| 2020 он | 15722 | 400 | 158 | 100 | 16380 |
| 2021 он | 2629 | 562 | 349 | 50 | 3590 |

### БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ /2016-2021 ОН/

| Он | Иргэний улсын бүртгэл | Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл | Хуулийн этгээдийн улсын бүртгэл | Архив | Нийт |
|---|---|---|---|---|---|
| 2016 он | 21 | 19 | 9 | 1 | 50 |
| 2017 он | 108 | 30 | 12 | 2 | 152 |
| 2018 он | 39 | 10 | 10 | 1 | 60 |
| 2019 он | 34 | 2 | 2 | 0 | 38 |
| 2020 он | 20 | 2 | 2 | 0 | 24 |
| 2021 он | 1 | 2 | 2 | 0 | 5 |

### ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ /2016-2021 ОН/

| Он | Иргэний улсын бүртгэл | Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл | Хуулийн этгээдийн улсын бүртгэл | Нийт |
|---|---|---|---|---|
| 2016 он | 23 | 0 | 0 | 23 |
| 2017 он | 41 | 3 | 5 | 49 |
| 2018 он | 35 | 7 | 2 | 44 |
| 2019 он | 30 | 23 | 7 | 60 |
| 2020 он | 88 | 49 | 4 | 141 |
| 2021 он | 102 | 96 | 2 | 200 |



Хялбаршуулсан журмаар 382 иргэнд торгууль, шийтгэл ногдуулсан.

43 иргэний Үндэсний энгийн гадаад паспортыг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд хүчингүй болгосон.

Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний улсын бүртгэл хөтлөх журмыг хэрэглэхтэй холбоотой анхаарах зөвлөмж чиглэлийг 4 удаа хүргүүлж ажилласан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн баталсан удирдамж, Хяналт шалгалтын газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 8/1364 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу Дорнод аймгийн 14 сумын улсын бүртгэгч нарын 2010 бүртгэлийн шилжилт хөдөлгөөний бүртгэлийн бүрдүүлбэр, нотлох баримтыг дэвтэр, ИУБ-22 маягт, мэдээллийн санд 03 дугаар сарын 26-ны өдрөөс 04 дүгээр сарын 01-ны өдрүүдэд шалгахад зөрчил илрээгүй дүнг УБЕГ-ын ХШГ-т хүргүүлэн ажилласан.

## ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ:

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр нийт 14071 бүртгэл бүртгэгдсэн. Үүнийг ангилвал:

**ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР НИЙТ 14071 БҮРТГЭЛ ХИЙГДСЭН**

- Иргэний гэр бүлийн байдлын бүртгэл 2612 буюу 18.6%
- Иргэний цахим үнэмлэх 3323 буюу 23.6%
- Шилжилт хөдөлгөөний бүртгэл 3426 буюу 24.3%
- Үндэсний энгийн ГП, ХЗ үнэмлэх 544 буюу 3.9%
- Дахин олгосон гэрчилгээ 410 буюу 2.9%
- Төрийн болон ТББ-д лавлагаа 334 буюу 2.4%
- Иргэнд олгосон лавлагаа 3038 буюу 21.6%
- Албан хэрэгцээнд ашигласан лавлагаа 384 буюу 2.7%



2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр “Гэр бүл болон гэрлэлт бүртгэл”, 2021 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр “Гэрлэлт дуусгавар болгох” талаар зөвлөмж хичээлийг иргэний улсын бүртгэгч нарт цахимаар хүргүүлэн ажилласан.

- 2021 оны 01 дүгээр сарын 15, 6 дугаар сарын 29, 10 дугаар сарын 05-ны өдрүүдэд сумын улсын бүртгэгч нарт иргэний улсын бүртгэлийн чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажил, алдаа дутагдал, цаашид анхаарах асуудал, шинэ программын талаар, шинээр батлагдсан үйлчилгээний хураамжийн талаар онлайн сургалт, мэдээлэл хийсэн. Мөн улсын бүртгэгч нарын өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн утас болон дотоод сүлжээгээр зөвлөгөө мэдээллийг тогтмол өгч мэргэжил арга зүйгээр ханган ажиллав.
